

УЛААНБААТАР ХОТЫН МУЗЕЙ ХАБЭА-Н ТАЙЛАН

2025 оны 06 сарын 19

Улаанбаатар хот

Хабэа-н осол аюулаас урьдчилан сэргийлэх бэлтгэл,
бэлэн байдлын үзлэгийг зохион байгуулсан тухай

Нийслэлийн удирдах ажилтнуудын 2025 оны 06 дугаар сарын 09-ний өдрийн шуурхай зөвлөгөөний Нийслэлийн Засаг даргын эдийн засгийн хөгжил, дэд бүтцийн асуудал хариуцсан нэгдүгээр орлогчоос өгсөн даалгаврын дагуу, Хөдөлмөрийн аюулгүй байдал, эрүүл ахуйн тухай хууль, Улаанбаатар хотын музейн ХАБЭА-н хяналтын журам зэргийн үндэслэн Музейн барилга байгууламж, эд хөрөнгийн ашиглалт, хамгаалалтад хяналт тавих, ажлын байран дахь хөдөлмөрийн аюулгүй байдал, осол аюулаас урьдчилан сэргийлэх, бэлтгэл, бэлэн байдлын үзлэгийг зохион байгуулж, байгууллагын даргын нэрэмжит үзлэг, шалгалтыг музейн ХАБЭА хариуцсан ажилтан С.Эрдэнэбат 2025 оны 06 дугаар сарын 16-18- ний өдрүүдэд зохион байгуулав. Үзлэгийг дараах үзүүлэлтүүдээр шалгаж явууллаа.

ХАБЭА хариуцсан ажилтныг сургаж, мэргэшүүлсэн байдал

ХАБЭА хариуцсан ажилтны сургалтад ажилтан С.Эрдэнэбатыг хамруулж сертификат авсан Улаанбаатар хотын музейн 2025 оны ХАБЭА-н үйл ажиллагааны төлөвлөгөөг батлуулж, мөрдөн ажиллаж байна. Холбогдох хууль, дүрэм, журмын дагуу музейн ажлын байр бүрд дээр аюулгүй ажиллагааны зааварчилгаа боловсруулан музейн захирлаар батлуулан, тухай бүр зааварчилгаа өгч ажиллаж байна. Эрсдэлийн үнэлгээ хийгдэж байгаа бөгөөд 06 сарын 30-ны дотор хийж дуусгахаар ажиллаж байна.



Ажлын тусгай хувцас, хамгаалах хэрэгсэл, цахилгаан тоног төхөөрөмжийн бэлэн байдал

Ажлын тусгай хувцас, нэг бүрийн хамгаалах хэрэгсэл худалдан авахаар 2025 оны төсөвт суулгасан 4 дүгээр улиралд худалдан авалт хийгдэнэ.



Цахилгаан багажийн бэлэн байдал, зөөврийн шат. Цахилгаан тоног төхөөрөмжүүдэд үзлэг хийхэд бүрэн бүтэн, хэвийн ажиллаж байсан. Зөөврийн шат бүрэн бүтэн, эд анги бүрэн хэвийн ажиллагаатай, анхны тусламжийн хайрцаг эм, боох материал бүрэн бүтэн байна.



Байгууллагын гадаад, дотоод орчны аюулгүй байдал

Музейн үзүүлэлийн танхим, ариун цэврийн өрөөний барилгын засварын ажил хийгдэж байгаа орчинд тухай бүр үзлэг шалгалт явуулан ажиллаж байна. Барилгын ажлыг гүйцэтгэж байгаа Гурвангис ххк-ын зүгээс анхааруулах тэмдэг байршуулаагүй, ажлын орчинд тамхи татсан зэрэг зөрчил гаргасан тул тус компанид холбогдох шаардлагыг тавьж 2025 оны 06 дугаар сарын 18-ны өдрийн №76 албан бичиг илгээсэн.

Музейн ажилтнуудад тус музейн ХАБЭА хариуцсан ажилтан барилгын засвар хийх үеийн аюулгүй ажиллагааны зааврыг нийт 16 албан хаагчдад 2025 оны 06 дугаар сарын 06-ны өдөр өгсөн.



Байгууллагын эд хөрөнгө ашиглалт, хамгаалалтад хяналт тавьсан тухай

Музейн захирлын 2024 оны 12 дугаар сарын 12-ны өдрийн А/57 дугаар тушаалаар 2024 оны жилийн эцсийн тооллогоор эд хөрөнгийг нэг бүрчлэн нүдээр үзэж тоолон, хөрөнгийн чанар байдлыг тогтоож ажилласан байна. Байгууллагын үндсэн хөрөнгийн дансанд 776,993,225 төгрөгийн эд хөрөнгө тоологдсон.

Байгууллагын эд хөрөнгөд бүртгэлээр тавих хяналт сайжирч 2025 оны эхний хагас жилийн байдлаар ажилтан бүрт эд хөрөнгийн картыг үнэн зөв хөтлөн явуулж, эд хөрөнгийн дутагдал гараагүй байна.

ХЯНАСАН:
МЕНЕЖЕР

Б.НАРАНГЭРЭЛ

ТАЙЛАН ГАРГАСАН:
ХАБЭА ХАРИУЦСАН АЖИЛТАН

С.ЭРДЭНЭБАТ